

МОНГОЛЫН АЖИЛЧИН АНГИЙН БАЙДАЛ (ТҮҮХИЙН СОЦИОЛОГИЙН АНАЛИЗ)

Ч.Тамир
Социологийн ухааны магистр

(Энэхүү өгүүлэл нь “Пост социалист орнуудын нийгмийн бодлогын харьцуулсан шинжилгээ” хэмээх судалгааны хүрээнд бичигдсэн болно.)

(Би үзэж харсан уншсан зүйлээ энэ номонд тодорхойллоо. Миний үзэл бодол, дурдсан баримтуудыг ялангуяа энэ ном хүмүүсийн гарт ороход олон талаас маргаж, халдан дайрна гэдгийг би урьдаас мэдэж байна, тийм явдалтай тулгарахад бэлэн байна. Гэвч миний санаа бодолд бүхэлд нь ямар нэгэн хэмжээгээр нөлөөлөх тийм ганц ч гэсэн баримт байгаа бол гаргаад өг гэж хөрөнгөтнийг өдөж байгаагаа нэг ч минут эргэлзэхгүйгээр дурдъя. Ф.Энгельс. Бремен, 1845 оны 2 дугаар сарын 15. Английн ажилчин ангийн байдал. 5-р хуудас.)

Өмнөтгөл

(1999 оны дэлхийн хүний хөгжлийн илтгэлд хийсэн харьцуулалтаас үзэхэд Монгол улс дотоодын нийт бүтээгдхүүнээр дэлхийн 174 орны дотроос 131 дэх байранд байна.)

1845 онд Германы Лейпциг хотноо Ф.Энгельсийн "Английн ажилчин ангийн байдал" гэсэн зохиол хэвлэгджээ. Тухайн үеийн английн ажилчин ангийн амьдрал, нийгмийн бодит байдлыг зохиолч өөрийн хувийн ажиглалт, статистик янз бүрийн бичиг баримтууд дээр тулгуурлан судалж энэхүү зохиолоо бичжээ. 1973 онд Намын түүхийн институтээс эрхлэн монгол хэл дээр орчуулан олны хүртээл болсон байна.

Өдгөө хэн ч тоохоо больсон энэ зохиолыг гарчиглах зуур манай орны өнөөгийн байдлыг харуулсан мэт надад санагдлаа. Өдөр тутам бидний хэвлэл мэдээллийн хэрэгслээр авч байдаг мэдээлэл ба биеэр үзэж харж байдаг бүхнийг 156 жилийн өмнө бичсэн номноос би олж үзсэн юм. Ингээд би та бүхэнд номны зарим хэсгээс системчлэн толилуулья. Дашрамд дурдахад хаалтанд манай орны судалгаа тоо баримтуудыг хавсаргасан нь XIX зууны Англид оршиж байсан "зэрлэг капитализмыг" манай өнөөгийн "иргэний нийгэмтэй" харьцуулан харах бололцоо олгох гэснийх билээ.

Монгол дахь хүний хөгжлийн зарим суурь үзүүлэлтүүд

1. Хоол унд ба хувцас

(Дэлхийн хүнсний байгууллагын илтгэлд хойд солонгостой хамт өлсч буй орны тоонд орлоо. Д.Ганхуяг. МН-Өнөөдөр 2001-2-13. ...Монгол айлын хоол тэжээлийн байдал хэрэгцээт хүнсний зүйлийн олдоц хүртээмж муу, эцэг эхийн ажлын ачаалал их, хүнс тэжээлийн талаар тэдний ойлголт хомс байна. Монголын хүн амын 51 хувь нь ундны усаар гачигдаж байна. Хүний хөгжлийн илтгэл. 30-р тал Хүнсний аюулгүй байдал сүүлийн жилүүдэд алдагдсан. Мн-Өнөөдөр 2001-12-5)

...Хоол ундны байдал нь дэндүү муу байна. Хотоос нэгдүгээр зэргийн хүнсний зүйлийг худалдан авч болох боловч их мөнгө хэрэгтэй. Гэтэл ажилчдад тийм мөнгө байх уу? 77-р тал.

...Ажилчин бүрийн ердийн хоол нь ажлын хөлснөөс шалтгаалан өөрчлөгдөж байдаг. Зэгсэн цалин хөлс авч байгаа ажилчид, сайн хооллож, өдөр бүр хоолных нь ширээн дээр мах, өөх байж байдаг. Бага цалин авч байгаа газарт зөвхөн ням гаригт буюу долоо хоногт 2-3 удаа мах иддэг. Бүр бага цалинтай хүмүүс мах идэж чадахгүй талхаар амиа зогоож байна. Маш олон айл өлсгөлөнгийн байдалтай байна. 81-р тал ...Өөр хоолгүй учраас ялзарсан төмс, жимс (алим Ч.Т) идэж долоо хоногийн цалингаа долоо хоног дуусахын өмнө зарцуулаад дуусвал, долоо хоногийн сүүлийн өдрүүдэд гэр бүлээрээ юу ч иддэггүй, идэвч арай өлбөрч үхэхгүй байх төдий юм идэж байдаг. Ийм амьдрал нь олон зүйлийн өвчинг аргагүй үүсгэж байдаг. Ялангуяа өрхийн тэргүүн өвдвөл гачигдал зовлон бүр ихэсдэг. 82-р тал. Ажилчны худалдан авч байгаа төмс нь их төлөв муу чанартай, бусад

ногоо нь шинэ биш, бяслаг нь хуучин доод зэргийн чанартай, өөх тос нь хуршмал, мах нь өөхгүй, удсан, хатуу, хөгшин малын буюу өвчтэй, үхсэн малын мах байх нь олонтоо тохиолдох бөгөөд тэн хагас нь гэмтэж муудсан мах байх нь цөөнгүй байдаг. 77-р тал. ...Хоолны чанар нь ч хэмжээ нь ч ажлын хөлсний хэмжээнээс шалтгаалдаг нь илэрхий бөгөөд бага цалин хөлстэй ажилчид ажилтай байсан ч, ялангуяа гэр бүлдээ олон хүнтэй бол өлсөж байдаг, тийм бага цалин хөлстэй ажилчид олон юм. Ялангуяа ажилчдын өрсөлдөөн нь хүн амын адилаар өсөж байгаа хотод тийм ажилчин олон байгаагаар барахгүй, бусад бүх хотод ч тийм байна.82-р тал.

...Ажилчин аль нэг цагт амралтын өдөр өмсөх ноосон сюртук, дээл эрхиш авах гэвэл (хямд үнэтэй барааны дэлгүүрт очиж), (эдэлгээний тулд биш харин худалдахын тулд) хийсэн хоёр долоо хоног болоход энд тэндээ цоорч салбаран урагддаг "devil's dust" гэдэг өөдгүй муу нэхмэл эд авах нь аргагүй болдог: эсхүл хуучин хувцасны худалдаачнаас сайн сайхан цагаа аль эрт өнгөрөөчихсөн хэдхэн долоо хоногийн эдэлгээтэй болсон хуучин сюртук дээл худалдаж авдаг юм. Ер нь олонхи ажилчны хувцасны шүүгээний дотор олигтой хувцас байхгүй бөгөөд сайн хувцсаа байн байн ломбардад өгч байна. Маш олон ажилчны, ялангуяа ирландчуудын хувцас нь нэлэнхүйдээ урагдаж ноороод нөхөхийн ч аргагүй болсон эсхүл анхных нь өнгийг огт таньж мэдэхийн аргагүй олон нөхөөстөй болсон байна.76-р тал. Даавуун хилэн гэдэг үг (fustian) ажилчны хувцас гэсэнтэй адил утгатай болсон, үүнд цэмбээр (broad cloth) гоёдог ноёдоос ажилчдыг ялгаж, тэд өөрсдийгөө ч даавуун хилэн хүрэмтэнгүүд(Fustian-jackets) гэж нэрэлдэг бөгөөд цэмбэ гэдэг нэр ч хөрөнгөтнийг тэмдэглэдэг үг болжээ.75-р тал.

2. Орон сууцнууд

(Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод нийт оршин суугчдын 50.9 хувь нь гэрт амьдарч байна. Нэг өрөөнд байранд дунджаар 4 орчим хүн амьдарч байна. Хүн амын тооллогын материал. МУҮСГ.

...УБ хотын агаарт агуулагдаж байгаа элдэв хорт бодис зөвшөөрөгдөх хэмжээнээс 1.5-20 дахин их байдаг нь оршин суугчдын эрүүл мэнд бие бялдрын хөгжилд сөргөөр нөлөөлж байна. Доктор Б.Бурмаагийн судалснаар “УБ” хот агаарын хүчтэй бохирдолтой гэсэн ангилалд хамаардаг ажээ... Үүний гол шалтгаан нь нэгдүгээрт автомашин хоёрдугаарт үйлдвэр ба станц гуравдугаарт гэрийн зуухаас болдог байна. ...2001 оны байдлаар Улаанбаатар хотод 25.000 автомашин 68.8 мянган тонн хорт бодис хаяж УБ хотын агаар бохирдлын 41 хувийг эзэлж байна. ...Мөн 43 хувийг Дулааны цахилгаан станцууд бохирдуулж байна. Эмч нар өвлийн цагт өглөө эрт ажиллаж байгаа замын цагдаа нар хорт утааны баг зүүхийг зөвлөжээ.)

...Бараг бүх үйлдвэрийн барилгууд хотын дундуур гарсан гурван гол даган байрласан байдаг.56-р тал. ...Том хот бүр нэг буюу хэдэн дүүрэгт нь ажилчин анги шигүү оршин суудаг ядуучуудын хороодтой байна. Гол нь хоёр буюу нэг давхар, үргэлжлүүлэн барьсан, бараг ямагт замбараагүй байрлуулсан, жижиг байшингууд нь ажилчин ангийн орон сууц болж байдаг.34-р тал. ...Тэндэхийн гудамжууд нь их төлөв цементлэгдээгүй бохир нүх, овор товонтой, ургамлын хог, малын шивх асгасан, цэвэр бохир усны шуудуугүй, тогтмол өмхий шалбаагтай байдаг.36-р тал Тэд олноороо тасалгаанд чихцэлдэн суудаг учраас шөнө амьсгалдаг агаар амьсгаа давхцаж бөглөрмөөр байдаг. ...Олон айл зөвхөн нэг тасалгаанд амьдарч байна.71-р тал. Тэнд бүтэн шилтэй цонх бараг байдаггүй, хана нь нурчихсан, хаалганы яс мод, цонхны жааз нь эвдрээд дөнгөж торж байдаг, хаалганы хавтсыг хуучин модоор нөхсөн буюу ор хавтасгүй байдаг, яагаад гэвэл хулгайчдын энэ хороололд хулгайлах юм юу ч байхгүй болохоор хаалганы хавтас зэрэг зүйлүүд нь ер нь хэрэггүй юм. Газар сайгүй хог үнс овоолж, хаалганы дэргэд асгасан бохир ус нь өмхий шалбааг болон тогтож байдаг. Ёг хашааны үүдэнд, хаалга ч үгүй маш бохир жорлон байх бөгөөд оршин суугчид явахдаа ялзарсан ялгадас ба тунасан шээсний шалбааг дундуур туулахаас өөр ямар ч арга байдаггүй. Миний энэ үгийг магадлахыг хүсвэл (Дэнжийн мянга, Баянхошуу, Яармаг, Чингэлтэй зэрэг Ч.Т) газруудаар яваад үзэхийг зөвлөө. Доторхи бөөн хог, ялгадас хаягдлаа эрэг дээрээ овоолдог (Дунд гол, Сэлбэ, Туул Ч.Т) голууд энэ байдлыг бүр бохир харагдуулна.58-р тал. ...Зарим газар (гэр хороололд Ч.Т) нэг хашаанаас нөгөөд орж бохир заваан мухар, догол гудамж, нүх сүвээр тэнэсээр байгаад эцэст нь хашаа явахаа мэдэхгүй болтлоо төөрдөг.59-р тал.

...Ажилчдын орон сууц нь газар бүхэнд муу байрлалтай, муу баригдсан, муу арчилгаатай, агаар муу сэлгэдэг, чийгтэй нойтон, эрүүл мэндэд харш байдаг. Тэнд маш шигүү суудаг, их төлөв нэг тасалгаанд цөөндөө л бүхэл бүтэн өрх айл унтаж байдаг, доторхи тавилга нь ядуу хоосны янз бүрийн байдалд таарсан байх бөгөөд хамгийн чухал хэрэгцээтэй гэрийн хэрэглэл огт байхгүй байдаг.83-р тал. ...Ус түгээгүүрийг зөвхөн мөнгөөр тавиулдаг, бас голууд нь ариун цэврийн зорилгод ашиглах аргагүй болтлоо бохирдсон болохоор тэднийг усгүй, өөрийгөө ариун цэвэр байлгах бүх хэрэгсэлгүй болгож байна. 106-р тал. ...Хотын хүн ам шигүү оршин суудаг бусад хэсэгт муу усны суваг огт байхгүй буюу байвал тэр нь ямар ч хэрэгцээгүй сувгууд байдаг. Зарим гудамжны зоориуд бараг хатдаггүй бусад хорооллын олон гудамжинд заваан нялцгай шавхай дүүрэн байдаг. Оршин суугчид нь нүүхүүдийг үнсээр дарж гудамжаа засах гэж байн байн дэмий оролддог боловч газар сайгүй бөөн бөөн хог овоорч байшингуудаас гаргаж цацаж байгаа угаадас нь нар салхинд хатах хүртлээ шалбааг болон тогтоож байдаг.49-р тал. ...Уг хотууд нь муу буруу зохион байгуулалттай бохир хашаа, харанхуй гудамж, нэлэнхүйдээ нүүрсний утаатай байдаг бөгөөд тэнд барилгын ганц материал болж байдаг тод улаан туйпуугаар аль дээр цагт баригдсан байшингууд гойд муухай сэтгэгдэл төрүүлдэг.51-р тал. ...Ажилчны орон сууцны хэрэгцээ яаж хангагдаж байгаа нь тэдний бусад хэрэгцээ яаж хангагдаж байгаагийн хэмжүүр болж болно.75-р тал. ...Том хотуудад хүн ам ийнхүү бөөгнөрсөн нь хамгийн тохиромжгүй үр дагаварт даруй хүргэж байна. Лондоны агаар нь хэзээ ч хөдөө нутаг шиг тийм цэвэр хүчилтөрөгч тийм цэвэр болохгүй. Хотын уг барилгууд нь агаар сэлбэхэд бэрхшээл учруулж байгаа учраас арай ядан нөхөгдөж байгаа тэр хэмжээлшгүй их хүчилтөрөгчийг газар зүйн гурав дөрвөн милл газар бөөгнөрсөн 2 сая хагас хүний уушиг 250 пийшин хэрэглэж байна. Хүний амьсгал шаталтаас бий болсон нүүрсхүчлийн хувийн жин нь хүнд учраас байшингуудын хооронд хоргодож агаарын гол урсгал нь байшингуудын дээвэр дээгүүр өнгөрдөг байна. Эдгээр байшинд оршин суугчид уушгиндаа хүрэлцэхүйц хэмжээний хүчилтөрөгч авч чаддагүй болохоор бие махбодь оюун ухаан ноозгойрч үйл ажиллагаа нь буурдаг байна. 105-р тал.

3. Ядуурал

(Монголын үндэсний статистикийн газрын 1998 онд хийсэн Амьжиргааны түвшний түүвэр судалгаагаар хүн амын 35.6 хувь нэн ядуу, ядуу байдалтай байна. Энэ нь 3 хүн тутмын нэг нь ядуу, нэн ядуу гэсэн үг бөгөөд тэдний нэг хүнд ногдох сарын орлого нь хамгийн их нь 14.674 төгрөг болж байна.

...МУИС Социологийн тэнхмээс 2000 онд хийсэн Гэр бүлийн суурь судалгаанд оролцогчдын 12.6 хувь нь ядуу буюу орлого нь өдөр тутмын зайлшгүй хэрэгцээгээ ч хангаж чаддаггүй,42.8 хувь нь ядуувтар буюу нь өдөр тутмын зайлшгүй хэрэгцээгээ хангахдаа өр зээл авах юмуу хэрэглээгээ хязгаарлахад хүрдэг бол 34.3 хувь нь дундаж амьдралтай буюу өдөр тутмын хэрэгцээгээ хангаад бас шаардлагатай хувцас хунараа ч авчихдаг байна. Баян ба чинээлэг хүмүүс дөнгөж 9 орчим хувийг эзлэж байна гэжээ.

...Ихэнхи хүмүүс далд өлсгөлөнгийн байдалтай байна.24-р тал Хуний Хөгжлийн Илтгэл 2000) (1998 оны мэдээгээр монголын нийт 2-5 насны хүүхдүүдийн 30 хувь нь давжаа, 10 хувь нь сульдаатай байна. Энэ нь тэдний хоол тэжээлтэй шууд холбоотой. ХХИ.2000)

...Олон хүн өлсгөлөнгөөр биш, харин өлсгөлөнгийн уршгаар үхэж байгаа үүнд: хоол ундаар байнга дутагдаж байгаагийн улмаас үхлийн аюултай өвчин тусч, хэлмэгдэгчдийн тоо нэмэгдэж, хүний бие махбоди маш их турж тамирдан, бусад нөхцөлд дажгүй өнгөрч бүрэн болох тохиолдлууд нь хүнд өвчин, үхэлд зайлшгүй хүргэж байна.34-р тал ...Ганц нэгхэн хүн өлбөрч үхэж байгаа нь гэвч маргааш ямар нэгэн ажилчинд энэ ээлж ирэхгүй гэдэг баталгааг түүнд хэн өгөх вэ? Хэн түүнийг ажлаар хангах вэ? Хэрэв эзэн нь маргааш ямар нэг шалтгаар буюу ямар ч шалтаггүйгээр ажлаас нь халбал өөр нэг эзэн (түүнд хэрчим талхны хөлс өгөхийг) зөвшөөрөх хүртэл тэр ажилчин гэр бүлийнхнийхээ хамт амьдарч байж чадахыг хэн баталж хэлэх билээ? Ажиллах хүсэл л байвал ажил олдоно, цэцэн мэргэн хөрөнгөтнүүдийн зөвлөн хэлж байгаа үнэнч, хөдөлмөрч, ариглан хямгадах зэрэг бусад сайн чанар, түүнийг аз жаргалд үнэхээр хүргэнэ гэж хэн түүнийг үнэмшүүлэх вэ? 35-р тал ...Энэ хүмүүст нэгэнт ажил олдохгүй бол нийгмийн эсрэг бослого хийхгүй болохоор гуйлга гуйхаас өөрөөр яах вэ? 95-р тал. Би Лондоны бүх ажилчид энэ гурван айл шиг туйлын ядуу байдаг

гэж нотлох гээгүй байна. Нийгэм нь нэг хүнийг бүрмөсөн дарлан давтсан тэр газарт арван хүн арай дээр амьдарч байдгийг би сайн мэдэж байна. Харин би хөдөлмөрч шударга, олон мянган өрх айл, нийтдээ хүний ёсонд нийцэхгүй ийм байдалд оршиж, пролетари бүр ийм байдлаас зайлахыг хичнээн чармайв ч тийм хувь тавиланд оногдож болох байна гэдгийг батлан хэлж байгаа юм. 40-р тал.

4. Өвчин

(Зөвхөн сүүлийн 4 жилийн байдлаар Монгол улсад 4-5 удаа тахал, 2-3 удаа шүлхий, холер, кор, дох зэрэг онц аюултай нийтийг хамарсан өвчнүүд гараад байна. Хүн амын зүгээс үүнийг хэвийн үзэгдэл хэмээн үзэх болсон байна.)

...(Улаанбаатарт Ч.Т) гарсан (холер) халдварт өвчний үед зарим гудамжуудыг (гэр хорооллын Ч.Т) цэвэрлэх оролдлого хийсэн ч үр дүнгээ өгөхгүй байна. Хоёр сарын дараа урьдын бохир байдал дахин бий болдог. 73-р тал. (Тахал, шүлхий, сүрьеэ, кор, холер, дох зэрэг өвчнүүд тархсаар байна. Ч.Т)

...Ажилчдын дотор наад зах нь их төлөв битүү байранд ажилладаг аж үйлдвэрийн ажилчдын дотор (бид энд зөвхөн тэдний л тухай өгүүлж байгаа шүү дээ) хүч чадалтай, хүдэр, эрүүл чиирэг хүмүүс тун цөөхөн дайралдана. Тэд бараг бүгдээрээ сул дорой болхи хөшүүн бас тэгээд бие бялдар нь доожоогүй, туранхай цонхигор царайтай ажил хийж байхдаа их хүч гаргадаг булчингуудаас гадна бусад булчингууд нь хөгжөөгүй байдаг. Тэд бараг бүгдээрээ ходоодны өвчтэй үүнийхээ улмаас сэтгэлээр гутарч ер нь гунигтай уруу царайтай байдаг. Тэдний суларч доройтсон бие нь өвчнийг эсэргүүцэх чадваргүй тийм учраас тэд өвдөх нь тун их байдаг. Тэгээд тэд эрт хөгширч залуудаа үхдэг. 114-р тал.

Монголын нийгмийн эдийн засгийн тулгамдсан зарим асуудлууд

5. Худалдаа наймаа

(Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгээс хийсэн шалгалтаас хүнсний захууда д зарагдаж байгаа бараануудын 40 орчим хувь нь хугацаа нь өнгөрсөн хортой гэж үзэж болохуйц хэрэглээний стандартыг хангаж үл чадах барааг худалдаж байжээ.)

...Ажилчдын хэрэгцээт зүйлсийг голдуу жижиг худалдаачид залгуулж байдаг. Тэд муу таваарыг дам худалдаж аваад хямдхан борлуулдаг. Ажилчид жаахан мөнгөөрөө муу чанартай ч гэсэн зайлшгүй хэрэгтэй зүйл хэрэглэхээс өөр аргагүй болдог. 77-р тал ...Ажилчдад олдсон мах нь ихэвчлэн идэж болохооргүй мах байдаг. (Хархорин зах дээр Ч.Т) нэгэн худалдаачин үхсэн малын идэж болохооргүй мах худалдаж байсан нь шалгалтаар илэрчээ. Мөн нохойн мах, муудсан мах зардаг зэрэг бүх тохиолдлыг дурдахын аргагүй юм. 1844 оны 1-6-нд Манчестерт арван нэгэн яргачин, идэж болохгүй болсон мах худалдсан хэргээр орон нутгийн шүүхэд (court leet) татагдан торгуулжээ. 78-р тал. Гурилд гипс шохой хийдэг, цайнд үүргэний навч зэрэг бусад хогийн ургамал хийж хатаагаад шинэ цай гэж худалддаг, тамхиуудыг янз бүрийн ой гутам зүйлээр хийдэг, үслэг даавууг урт болгохын тулд сунгадаг тэр нь хатсаны дараа агшдаг, гэх мэтийн луйвар олон мянгыг дурдаж болох байна. Энэ заль мэхэнд түүнийг хэрэглэхээс аргагүй ажилчнаас өөр хэн хэлмэгдэх вэ? 79-р тал. Энэ бүх хуурамч, их төлөв хордсон хүнсний зүйлийг ядуучууд худалдан авдаг бөгөөд жижиг мухлагнаас худалдан авах, тэр ч байтугай арга буюу зээлээр авах нь цөөнгүй байдаг, гэтэл жижиг мухлагийн эздийн капитал нь бага, тэгээд их зардлаар ажил хэргээ бүтээдэг болохоор том худалдаачин шиг хямд үнээр худалдаж чаддаггүй. Гэтэл өрсөлдөөний доогуур үнээр худалдах явдал шаардлагатай байдгийн улмаас санаатай болон санамсаргүй ч хуурамч таваар худалдах хэрэгтэй болдог. Маш цөөхөн хуурамч бараа зарсан хэргийг хуулиар шийтгэсэн байна. Харин английн ажилчдыг бараа таваарын чанарын талаар мэхлэхээр барахгүй тоо хэмжээний талаар мэхэлж байдаг. Жижиг худалдаачдын жин хэмжүүр нь их төлөв буруу байдаг. Ийм зөрчлийг шийтгэсэн тоо томшгүй олон торгуулийн тухай цагдаагийн газрын мэдээг өдөр бүр олж уншиж болно. 80-р тал. Тэнд худалдаагаа гудамжинд ил задгай хийж, сагснуудтай ногоо жимс, өрөөстэй байдаг. Энэ бүгд зорчих замыг бүр ч бөглөөстэй болгож тэгээд тэр бүхнээс ой гутам үнэр гарч байдаг. 36-тал. Илүүдэл хүмүүсийн олонхи нь үүргийн жижиг худалдаа хийдэг ялангуяа Бямба гаригийн орой нь бүх

ажилчид гудамжинд гарч ирэх үед ийм худалдааг хичнээн олон хүн хийдэг нь харагддаг. Тоо томшгүй олон эрэгтэйчүүд эмэгтэйчүүд хүүхдүүдийн ботинкны үдээс татуурга, мөрөвч, жүрж жигнэмэг зэрэг янз бүрийн жижиг зүйлсийг бариад худалдаж байдаг. Бусад цагт ч гэсэн жүрж аваарай жигнэмэг аваарай гэсэн тийм үүргийн худалдаачид алхам бүр дайралдана. Тэрчлэн тэд шүдэнз зэрэг янз бүрийн зүйлс худалддаг. Үүнд: лац гал асаах баталгаатай найруулсан бодис зэргийг худалдаж байдаг.

6. Бизнесменүүд

(Доктор Г.Чулуунбаатарын судалгаанаас үзвэл манай томоохон компаниудын 70 хувь нь бизнес төлөвлөгөөгүй үйл ажиллагаа явуулдаг байна. Өнөөгийн бизнес эрхлэгчид 2000 он. Хавсралт ...Судалгаанд хамрагдсан бизнесменүүдийн дөнгөж 3.9 хувь нь шударга зан чухал хэмээн үзсэн байна. Нийслэлийн хүн амын эрүүл мэнд судалгааны тайлан.)

...Английн хөрөнгөтөн шиг ёс суртахуунаа хамгийн их алдаж, явцуу эрх ашгийн хойноос хөөцөлдөж, хамгийн найдваргүй эвдэрсэн, дотроосоо хамгийн их ялзраад, ямарваа нэг дэвшилт гаргах авьяас чадваргүй болсон тийм ангийг би хэзээ ч үзээгүй билээ. Тэд мөнгөний хойноос хөөцөлдөхөөс өөр юмыг дэлхийгээс олж хардаггүй, баяжихын хойноос л хөөцөлдөж, түргэн баяжихаас өөр сайн сайхныг, мөнгө алдахаас өөр зовлонг мэддэггүй юм.288-р тал Амьдралын бүх харилцааг орлогынх нь хир хэмжээгээр үнэлж үздэг бөгөөд мөнгө оруулдаггүй юм бүхэн огт дэмий, ашиг тусгүй идеализм гэж тооцогддог байна. Чухам ийм учраас мөнгө хожих аргын тухай шинжлэх ухаан болсон эдийн засгийн ухаан бол тэдний (бизнесменүүдийн) дуртай шинжлэх ухаан юм.289-р тал. ...Тэд байнга өөрчлөгдөж байдаг үнийг харгалзан, бэлэн байгаа нөөц хэрэгцээний тухай найдваргүй дүгнэлт хийн, бүх юмыг аз харж хийдэг. Ямар нэгэн зах зээлийн тухай аятайхан мэдээ сонсогдмогц хүн бүр тийшээ орж тэр зах зээл нь даруй бараа таваараар дүүрээд борлуулалт зогсон юмны үнэ бууран унахад үйлдвэр сүйрч ажилчдаараа хийлгэх юм үгүй болдог.91-р тал. ...Тэд хүн бүрийг хүн гэж үздэг харин хөрөнгөтөн л ажилчныг хүн гэж бүрэн үздэггүй, чухам ийм учраас ажилчид хэдийгээр мөнгөөр хөрөнгөлөг ангиас илүү их гачигдаж байдаг боловч мөнгөнд шунах нь бага эелдэг сайхан санаатай байдаг. Тэдэнд мөнгө зөвхөн юм худалдан авч болдогоороо хэрэгтэй зүйл болж байдаг. Харин хөрөнгөтөнд мөнгө бол онцлог чанартай эрхэм чухал эрдэнэс бурхан тэнгэр шиг чухал эрдэнэс байдаг учраас мөнгө хөрөнгөтнийг "ашиг хонжоонд шунагч" адгийн бузар булай "хүн" болгодог юм. Аль болохоор их завшихын тулд юунаас ч буцдаггүй бөгөөд мөнгөнийхөө тулмыг дүүргэх явдлыг амьдралынхаа зорилго гэж үздэг хөрөнгөтнийг бодвол мөнгөнд бишрэн наминчлах үзэл огт харш байдаг ажилчид мөнгөнд хөрөнгөтөн шиг шунахай байдаггүй.13-р тал.

...Ажилчин нь өлсөж байгаа эсэх нь хөрөнгөтөнд ер пад алга харин өөрөө баяжиж байвал болох нь тэр. Фабрикийн эзнээс ажилчидтай харьцаж байгаа харилцаа хүний ёсны харилцаа биш харин эдийн засгийн харилцаа байна. Фабрикийн эзэн бол "капитал", ажилчин бол "хөдөлмөр" юм. Ажилчин хүн тэр хийсвэрлэлд автагдахгүйгээр өөрийгөө "хөдөлмөр" биш, харин бусад шинжийн зэрэгцээгээр хөдөлмөрлөх авьяасыг агуулж байдаг хүн мөн хэмээн нотлон ажилчин хүнийг зах зээл дээрээс "хөдөлмөр", таваар болгож худалдан авах буюу худалдаж огт болохгүй гэж үзэх тэр үед хөрөнгөтөн мухардмал байдалд орно. Хөрөнгөтөн ажилчин хоёрын хоорондох худалдан авах худалдах харилцаанаас гадна өөр ямар нэгэн харилцаа байгааг хөрөнгөтөн ойлгож чадахгүй. Хөрөнгөтөн ажилчдыг хүн гэж үзэхгүй зөвхөн "гар" (hands) гэж үзээд ажилчдыгаа нүүрэн дээр нь үргэлж тэгж нэрлэж байна.

7. Капитал

(Өмч хувьчлалын талаар явуулсан судалгаанаас харвал нийт оролцогчдын 91 хувь нь өмч хувьчлалыг ямар нэгэн хэлбэрээр шударга бус явагдаж байна хэмээн үзжээ. Түгээмэл асуулт хариулт. 2000. Монголын өмч хувьчлалын хөтөлбөр.)

...Аж үйлдвэр нь том капиталын тусламжтайгаар асар том үйлдвэр байгуулж, тэгснээрээ гар урлалын жижиг хөрөнгөтнүүдийг улам хоосруулан, ганц ганцаараа ажилладаг гар урчуудыг зах зээлээс хавчин төрж, байгалийн хүчийг өөртөө захирч байдаг учраас их капитал шаардаж байна. Хүмүүс ч капиталын адил төвлөрч байгаа бөгөөд учир нь ажилчин хүнийг өөрөө өөрийгөө фабрикийн эзэнд өгч ашиглуулан, оронд нь тэр эзнээс ажлын хөлс нэртэйгээр хувь авдаг зөвхөн нэг

маягийн капитал л гэж үздэг байна. Том үйлдвэрийн газар нь нэг байранд олон ажилчныг хамт хөдөлмөрлүүлэхийг шаарддаг, учир жижигхэн фабрикийн дэргэд ч бүхэл бүтэн суурин бий болдог юм. 29-р тал. ...Өмчийн төвлөрөл зогсоож саатуулахын аргагүй хүчтэй явагдаж, нийгэм том капиталистууд ба хөрөнгө чинээгүй ажилчдад хуваагдах явдал өдөр ирэх тусам улам хурцдан, үндэстнүүдийн аж үйлдвэрийн бүх хөгжил нь маш том алхмаар хямрал руу ойртож байна. 219-р тал.

...Ажилчдыг хэрэглэх эрэлт хүсэлт нэмэгдвэл тэдний үнэ дээшилдэг: тэднийг хэрэглэх эрэлт бууран унавал үнэ нь бууран унадаг: ажилчид хэрэглэх эрэлт хүсэлт тэдний тодорхой хэсэгт нь худалдан авагч олдохгүй болтол тэгж унаад "дарагдаж хэвтэх" болвол, тэд ажилгүй болж, ажилгүй амьдрах аргагүй учраас өлбөрч үхнэ. Учир нь улс төрийн эдийн засгийн хэлээр хэлбэл тэднийг амьдруулахаар зарсан хөрөнгө нь газар хаясан мөнгө мэт болоод "өөрийгөө нөхөн үйлдвэрлэхгүй" тул энэ хэрэгт хэн ч капиталгаа зарцуулахгүй. Энэ утгаар үзвэл, хүн амын өсөлтийн тухай ноён Мальтусын онол үнэхээр зөв юм. Энэ боолчлол, хуучин ил боолчлол хоёрын бүх ялгаа нь гэвэл орчин үеийн ажилчин үүрд худалддаггүй, харин түр хугацаагаар, өдрөөр, долоо хоногоор, жилээр худалддаг, бас нэг хүний боол биш, харин бүх хөрөнгөлөг ангийн боол учраас түүнийг нэг өмчтөн өөр өмчтөнд худалддаггүй, харин тэр өөрөө өөрийгөө тэгж худалддаг нь аргагүй болдог учраас эрх чөлөөлтэй мэт харагддаг л оршиж байгаа юм. Энэ эрх чөлөөтэй мэт байдал нь нэг талаар ажилчин зарим нэг бодитой эрх чөлөө олгох ёстой байлаа ч гэсэн нөгөө талаар түүний хоол ундтай байх баталгааг түүнд хэн ч олгодоггүй, түүний эзэн болсон хөрөнгөтнүүд түүний ажлыг ашиглах, түүний амьдарч байхыг сонирхохгүй болохдоо түүнийг дуртай цагтаа хөөж гарган, өлбөрч үхэхэд хүргэж болох учраас дээрх ялгаа нь ажилчинд-боолын мөн чанарыг ер өөрчилсөнгүй. 88-89-р тал.

8. Ажлын байр

(Өнөөдөр ихэнхи гэр бүлийг эмэгтэйчүүд ажил хийж авч явж байна. ...2001-12-10 ны өдөр Сонгинохайрхан дүүргийн удирдлага 10 жилийн сургуулийн багш нарын цалинг гулууз махаар тавьсан байна. Тэд эсэргүүцсэн хэдий ч амжилтанд хүрч чадсангүй. Ийгл телевиз.2001-12-10)

...Үйлдвэрийн ажилчдын 80-90 хувь нь эмэгтэйчүүд тэр тусмаа 70 орчим хувийг 16-28 насны хүүхнүүд эзэлж байна. Гэтэл эрэгтэйчүүд дөрөвний нэгд нь ч хүрэхгүй. 154-р тал Ингэж эмэгтэйчүүд үйлдвэрт ажил хийх нь гэр бүлийг зайлшгүй эвдэж гар дээр үндэслэсэн орчин үеийн нийгэмд ёс суртахуун алдагдаж байна. 155-р тал.

...Ажилчид "Truck" хэмээн нэрлэж заншсан хөдөлмөрийн хөлсийг таваараар төлөх явдал нийтлэг дэлгэрсэн байна. Ялангуяа хөдөө орон нутагт үүнийг өргөн хэрэглэж байна. 192-р тал.

...Үйлдвэрт ажилладаг эмэгтэйчүүд жирэмсэн болвол амаржих хүртлээ ажилласаар байдаг. Тэгэхгүй ажлаасаа эрт гарчихвал түүний оронд өөр хүнийг авч, ажлаас нь халчих аюулд учирч болохын дээр ажиллаагүй байсан хугацаандаа ажлын хөлс авахгүй болох нь бүрэн ойлгомжтой шүү дээ. Жирэмсэн эмэгтэйчүүд хүртэл өдөр бүр 12-13 цаг босоо ажилладаг. 172-р тал. Бараг бүх үйлдвэрт (гадаадын хөрөнгө оруулалттай Ч.Т) байдал ийм байна. Үйлдвэрийн орчноос хамаарч залуу охидын биеийн байдал хэвийн бус болж байна. 173-р тал. ...Зарим үйлдвэрийн эзэд бүр ч зэрлэгээр авирлаж олон тооны ажилчдыг 30-40 цагаар тасралтгүй ажиллуулж байсан, тэгэхдээ долоо хоногт хэд дахин тэгж ажиллуулж байсан байна. Учир нь тэдгээр үйлдвэрийн хоёрдох ээлж бүрэн бус байсан бөгөөд ээлж гэгч нь зөвхөн ажилчдын заримыг сольж ганц хоёр цаг унтах бололцоо олгох зорилготой байв. Үүнийг ажилчид эсэргүүцэж байсан зарим баримт байна. 163-р тал. ...Ажилчдыг ажил дээр хооллох байдал тун муу байна. Тэднийг бараг дан ганц өвчтэй, үхсэн малын махаар буюу бээсэн мах, муудсан загас, үхсэн гахайн махаар хооллуулж байна. Ийм байдал нь нийтийн үзэгдэл болсон ба ийм хоолтой байдгийн зайлшгүй үр дүн нь гэдэс дотрын ба бусад өвчин олонтоо тусч байгаа явдал юм. 211-р тал. Лондоны эмэгтэй оёдолчид ерөнхийдөө үүнээс дутуугүй хэрцгий боловч арай л эрс шууд бишээр мөлжигдөж байна. Бэлхүүвч оёдог охидын хөдөлмөр хүнд, ядаргаатай, нүдэнд хортой байдаг. Тэд ямар хөлс авч байна вэ гэвэл үүнийг би мэдэхгүй. 220-р тал.

9. Хүнд хүчир хөдөлмөр

(Улаанбаатарт дунджаар 960 нүүрсний уурхай хууль бус байдлаар ажиллаж байгаагийн 200 гаруй нь Налайх дүүрэгт байгаа бөгөөд тэнд зөвхөн өнгөрсөн нэг жилийн байдлаар 14 хүн амь насаа

алдсан байна. UB POST №45. 2001 Монголд үйл ажиллагаа явуулж буй алтны уурхайнуудад ажилладаг алт шигшигчдийн хувьд ажлын нөхцөл онцгой хүнд байна.

...Нөхөр маань гурван жилийн өмнө нурангид дарагдаж талийгаач болсон. Ер нь уурхайчид олсон хэдийгээ архи, хүүхэн хоёрт өгчихдөг юм. Орой болоход биеэ үнэлэх гэсэн охидууд, найруулсан спирт зарах гэсэн авгай нар, уурхай руу цувж өгдөг. Зарим үед гэрээ (овоохой байв) хорин минут хөлслөх явдал гарна.Над шиг ийм үйлчилгээ хийдэг эмэгтэйчүүд олон бий.Налайхын уурхайн сурвалжлага МН-Өнөөдөр 2001-12-14)

...Уурхайд ажилладаг хүүхдүүд гэртээ орж ирэнгүүтээ нам унтдаг учраас эцэг эх нь унтаагаар нь гар нүүрийг нь угааж, оронд нь хэвтүүлэх явдал гардаг байна.256-р тал. ...Уурхайд ажилладаг хүмүүсийн биеийн байдал нь тэдний эрхэлж байгаа хөдөлмөртэй холбоотой олон янзын өвчин тусч байна.257-р тал. ...Чулуун нүүрсний уурхайнууд хамгийн аймшигтай гэнэтийн осол гардаг газар болж байна. Цаашилбал уурхай буюу уурхайн зарим хэсэг нурж ажилчдыг дарж алах буюу тахир дутуу болгох явдал байн байн гардаг. 260-р тал. ...Бүх нүүрс малтагчдын хэт ядаргаа нь ууж согтуурахад хүргэж байна. 261-р тал. ...Гэргий нь нөхрийнхөө адилаар гадуур ажилладаг учраас хүүхдүүдээ бүр дөнд нь орхидог, байрандаа түгжээд үлдээдэг буюу ямар нэг хүнд хөлс өгч харуулдаг айл олон байдаг. Ийм хэдэн зуун хүүхэд янз бүрийн золгүй явдлын улмаас үхэж байдгийг гайхах юм алга. Английн том хотууд шиг хүүхэд тэгэж морин тэрэг морины хөлд дайрагдан, усанд живж, галд түлэгдэн үхдэг тийм газар хаана ч байхгүй. Ялангуяа буцламтгай халуун усанд хүүхдүүд түлэгдэж эсвэл шалзарч үхэх тохиолдол олонтоо тохиолддог. 118-р тал. ...Энэ тэр гэх ялгаваргүйгээр бүх тойргийн нүүрс малтагчид энэ бүх өвчний улмаас эрт хөгширч, бүр 40-өөд наснаасаа хойш ажлын чадваргүй болдог байна.258-р тал.

Нийгмийн институт ба нийгмийн харилцаа

10. Гэр бүл

(Өрхийн тэргүүний талаархи уламжлалт үзэл өөрчлөгдөж байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан хүмүүсийн 13 хувь нь өрхийн тэргүүн эмэгтэй хүн байж болно буюу 7 хувь нь хэн ухаалаг овсгоотой нь өрхийн тэргүүн байх ёстой хэмээн хариулжээ. Гэр бүлийн харилцааны уламжлал шинэчлэл. Төслийн эрдэм шинжилгээний тайлан. Өрхийн тэргүүн. Түүний хэв шинж. Ч.Тамирын илтгэл.)

...Нөхөр нь өдөржин ажилладаг, бас гэргий ахмад хүүхдүүд нь өдөржин ажиллах нь цөөнгүй байдаг учраас зөвхөн өглөө оройд л уулздаг, архинд нэвчсэн гэр бүлийг ямар гэр бүл гэх юм? Ёс суртахууныг алдагдуулагч хэрүүл маргаан гэр бүл дотор байнга гарч байна. Гэр бүлийн бүх үүргийг юуны урьд хүүхдүүдийн талаархи үүргийг ойшоодоггүй явдал ажилчин ангийн дунд ихэсчээ. Тэгсэн мөртлөө хүүхдээ ёс суртахуунтай хүмүүс болохыг хүсэцгээж байна.140-р тал Эмэгтэйчүүд фабрикт ажил хийх нь гэр бүлийг зайлшгүй эвдэж, гэр бүл дээр үндэслэсэн орчин үеийн нийгэмд энэ байдал нөхөр гэргий хоёрт ч, үр хүүхдүүдэд нь ч ёс суртахууныг хамгийн их алдуулагч үр дагавартай болж байна. Хүүхдийн амьдарлын эхний жилүүдэд түүний төлөө санаа тавих, түүнд эхний хамгийн жирийн хайр энэрлийг өгөх завгүй эх хүн, хүүхэддээ огт өөр хүний хүүхэд хандаж байгаа юм шиг хайхрамжгүй, ямар ч санаачлагагүй хандах нь зайлшгүй юм. Ийм нөхцөлд өсч бойжсон хүүхэд хожим нь гэр бүлээсээ бүр хөндийрч, дэндүү тасархай ганц нэгээрээ амьдарч дассан учраас дараа нь гэр бүлтэй болохдоо түүндээ хэзээ ч өөриймсөг байхгүй бөгөөд энэ нь ажилчны дунд гэр бүл эвдрэх шалтгаан болж байна.156-р тал. ...Одоо эмэгтэйчүүд урьдын эрэгтэйчүүд шиг өрх гэрийнхээ эд хогшлын ихэнхийг буюу тэр ч байтугай бүгдийг нь өөрөө олж байгаа нь эрэгтэйчүүдийг ноёрхох үндэс болж байна. Орчин үеийн өрх гэр задран унаж байгаа баримт бол өрх гэрийг холбогч сэжим нь эр эмийн дурлал биш, харин эд хогшил амины ашиг сонирхол болж байгааг нотолж байна. Зарим эхнэрүүд гэрийн эзэн байдаг шиг бас хүүхдүүд бас гэрийн эзэн болж байна. Фабрикт өсөж торнисон, есөн настайгаасаа ажил хийж эхэлсэн охин гэрийн ажил сураагүй байх нь аяндаа илэрхий бөгөөд үүний улмаас фабрикийн ажилчин эмэгтэйчүүд цөмөөрөө энэ талаар ямар ч туршлагагүй, гэрийн аж ахуй эрхлэн удирдаж чадахгүй байдаг юм. Тэд юм оёж ч, сүлжиж, хоол хийж, юм угааж ч чаддаггүйгээр барахгүй, гэр зуурын ажил мэддэггүйгээс гадна нялх хүүхэд асрах тухай бүр

мэддэггүй байна.158-159-р тал. ...Үүний шалтгаан нь энэ нутагт эмэгтэйчүүд хүүхдүүд хийх ажил хангалттай байдаг боловч эрэгтэйчүүдийн хийх ажил байдаггүйтэй холбоотой. 157-р тал.

11. Сургууль

(...Нийт хүүхдүүдийн 15 орчим хувь нь огт сургуульд хамрагдахгүй байна....Ядуу эцэг эх хүүхдээ сургуульд явуулахад улам хэцүү болж байна.Монголын Хүний Хөгжлийн Илтгэл. 2000.26-р тал.)

...Өдрийн сургуулиуд нь муу, хөдөлмөрийн чадваргүй болсон ажилчид юмуу, цалин хөлс авахын тулд багш болсон, багш хүнд маш хэрэгтэй ёс суртахууны чанар дутмаг, олон нийтийн хяналтанд огт өртдөггүй, тийм хүмүүс байдаг.120-р тал. ...Хүүхдийг бүр долоон настайгаас нь хамгийн хожимдоо арван хоёр настайд нь сургуулиас гаргадаг.215-р тал ...Маш олон хүүхэд үйлдвэрт (гудамжинд зах дээр Ч.Т) ажилладаг тул сургуульд суралцаж чаддаггүй байна. Өдөр ажиллагсдад зориулсан оройн сургуулиудад хүн бараг суралцдаггүй, тэр сургуулиуд нь ямар ч ашиг өгдөггүй байна. Арван хоёр цагийн хөдөлмөр хийж туйлдан ядарсан бага залуу насны ажилчдыг дахиад оройн найман цагаас арван цаг хүртэл хичээлд суулгах гэвэл дэндүү их шаардлага болох биз ээ. Орой хичээллэдэг хүмүүсийн олонхи нь хичээл дээрээ унтаж байдгийг судалгаа гэрчилж байна.120-р тал. ...Ням гаригийн сургуульд хэдэн жил явсан нэг хүүхэд нэг үсгийг нөгөөгөөс нь ялгаж чадахгүй байв 217-р тал. ...Залуучууд ням гаригийн өдрийг зоосдох буюу нохой турхирч тоглон гудамжинд өнгөрүүлдэг байна. Тэд зуушны газар дуртай очиж тэнд янаг хайртынхаа хамтаар шөнө орой болтол цаг өнгөрүүлээд, дараа нь хос хосоороо тасран салж аминчлан зугаалдаг. Зарим нь хөзөр тоглож дуу дуулан бүжиг хийж цөм архи ууцгааж байв.215-р тал.

12. Төр засаг

(...Энэ төрийн дор амьдрахад тав тохь үнэхээр муу байна.Д.Ганхуяг МН-“Сульдаатай төр” Өнөөдөр 2001-10-18)

...Ажилчин ангийн байдал бол английн ард түмний асар олонхийн байдал юм. Өчигдрийн ажлаар олсон зүйлийг өнөөдөр идэж дуусгадаг, ...Өв хөрөнгөгүй болсон энэ олон сая хүний хувь тавилан ямар байх тухай асуудал нь реформын тухай хуулийн төсөл гарснаас хойш нийт үндэстний асуудал болжээ. 124-р тал.

13. Нийгмийн харилцааны шинж чанар

(1996 онд ФСЭХ-гээс хийсэн судалгаанаас үзвэл хүмүүсийн хоорондох харилцаанд албан тушаал хөрөнгө чинээ харж нөхөрлөсөн бялдууч харилцаа, хариу шан харамж авахыг хичээсэн тооцоотой харилцаа, ашиг хонжоо хайсан түр зуурын чанартай харилцаа тодорхойлогч шинжтэй байна. ...Мөнгө эрхэм үнэт зүйл болохын хамт хөдөлмөрлөхгүйгээр мөнгөжиж, хөрөнгөжиж болдог гэсэн гаж ойлголт түгээмэл байгаа нь гэмт хэрэг хулгай дээрэмд иргэдийг түлхэж, авилгал хээл хахууль руу төрийн ажилтнуудыг татаж байна. ШУА. ФСЭХ. Нийгмийн шинэчлэл: амьдралын хэв маягийн өөрчлөлт.2001)

...Англид нийгмийн дайн ид өрнөж байна. Хүн бүр өөрийгөө өмгөөлж өөрийнхөө төлөө бусад бүх хүнийг эсэргүүцэн тэмцэж байгаа бөгөөд, асуудлыг дан хар амиа хичээх үзлийн үүднээс, тухайлбал яавал өөрт нь илүү ашигтай байх үүднээс шийдэж байна. Ойр дотны хүмүүстэйгээ хүртэл эелдэгээр тохиролцохыг бодохгүй, бүх зөрчилдөөнийг айлган сүрдүүлэх, өөрөө дур зоргоороо буюу шүүхээр шийдвэрлэж байна. Товчоор хэлбэл хүн өөр хүнийг өөрийнхөө замаас зайлуулбал зохих дайсан буюу их сайндаа л өөрийнхөө зорилгод ашиглаж болох хэрэглүүр гэж үзэж байна. Гэмт хэрэг жилээс жилд улам хурц, ширүүн эвлэршгүй болж байна.143-р тал. ...Амин хувийнхаа эрх ашгийг бодсон энэ явцуу үзэл бол манай орчин үеийн нийгмийн үндсэн, түгээмэл зарчим мөн. Хүн төрөлхтөн тус тусдаа өөрийн тусгай зарчимтай, өөрийн тусгай зорилготой нэгжүүдэд бутран тасарсан явдал, энд дээд хэмжээндээ хүрчээ.33-р тал. ...Эрхэмсэг Штирнерийн хэлсэнчлэн хүн бүр нөгөө хүнээ зөвхөн ашиглаж болох зүйл гэж үзэж: хүн бүр нөгөөгөө мөлжиж, тэгээд хүчтэй нь хүчгүйгээ хохироож, тэд өөрөөр хэлбэл капиталист этгээд бүх юмыг өөртөө завшин авч, сул дорой ард түмэнд, өөрөөр хэлбэл ядуучуудад зөвхөн амьдрах төдий юм үлдэж байна. 33-р тал Мөнгөтэй хүн бол "хүндтэй", "дээд зэргийн хүмүүст багтаж" (the better sort of people), "нөлөөтэй" болоод (influential) өөрийнхөө орчныг бүх талаар ааглаж байдаг. Бүх хэл ярианд наймааны шинж шингэж, бүх харилцаа худалдааны нэр томъёо, эдийн засгийн ойлголтоор илэрхийлэгдэж байна. Эрэлт, нийлүүлэлт supply and demand гэдэг бол англи хүний ойлголтонд хүний бүх амьдралыг багтаадаг

тийм томъёолол юм. Үүний улмаас амьдралын бүх салбарт чөлөөт өрсөлдөөн болж үүний улмаас удирдлага, эмнэлэг, хүмүүжилд, laissez faire, Laissez aller гэдэг зарчим тогтож байгаа бөгөөд энэ нь ойрын үед шашны талаар ч тогтож магадгүй юм. 290-р тал. Өрсөлдөөн бол орчин үеийн иргэний нийгэмд ноёрхож байгаа бүхний эсрэг бүхний дайны хамгийн бүрэн илэрхийлэл юм.85-р тал.

Монголын нийгэм дэх гаж үзэгдэл

14. Гэмт хэрэг

(Судалгаанаас үзвэл насанд хүрсэн бүх хүн амын 70 гаруй хувь нь сүүлийн нэг жилийн байдлаар ямар нэгэн гэмт халдлагад өртсөн байна. 2000 Шинжээч судалгааны төв Цагдаагийн газар бүртгүүлсэн зөвхөн танхайн гэмт хэрэг 1991 онд 1000 хүн тутамд 76 оногдож байсан бол 2000 он гэхэд 1000 хүн тутамд 156 болж 2 дахин өссөн байна. Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтсийн ажилтан .К.Женисгулийн судалгаа. ...Зөвхөн 2000 онд 1000 орчим хүн зуурдаар бусдад хөнөөгдсөн хэмээн ХЗДХ сайд Ц.Нямдорж хэлээд “Монголд багахан дайн гарсан юм шиг боллоо” хэмээн мэдэгджээ. Мн-Өнөөдөр 2001-12-11 ...2000 онд санаатайгаар бусдын амь насыг хөнөөсөн хэрэг л гэхэд 400 гаруй гарч өдөрт л нэгээс илүү хүн бусдын гарт санаатайгаар алуулж байна. ҮСГ. 2000)

...(Монголд ядуурал өсөхийн Ч.Т) хэрээр гэмт хэргийн тоо өсч байна. 140-р тал. Нийгэм бүрэн задарч байгааг бид одоо ч үзэж байна. Нийгмийн бүх хэлхээ холбоо суларч байгаагийн хамгийн ноцтой жишээнүүдийг бид одоо ч гэсэн сонин бүрээс үзэж байна. Миний дэргэд овоолоотой байгаа олон сонинны нэгийг аваад үзье. Захын нэг сонин гурван өдрийн мэдээнд үйлдвэрийн ажилчид цалин хөлсөө нэмүүлэхийн тулд ажил хаясан, (3 хүний амь насыг хохироосон Ч.Т) (Центрпойнтод) зодоон гарсан, 10 настай хүүхэд амиа хоролсон, (Голомт банкийг) дээрэмдэхээр завдсан, эхнэрээ зодож бэртээсэн, хулгай орсон, татвараас зугтсан, луйвардсан, хүчиндсэн зэрэг хэргүүд гарсан байна. Бусад сонинууд энэнээс долоон дор зүйлийг бичиж байна. 141-р тал. 1842 онд гэмт хэрэгтнүүдийн уншиж бичиж огт чадахгүй, 58.32 хувь нь бичиг бага мэддэг, 6.77 хувь нь уншиж бичиж сайн чаддаг, 0.22 хувь нь нэлээд дээгүүр боловсролтой байсан ба 2.34 хувийнх нь боловсролын байдал нь мэдэгдээгүй байна. Шотландад гэмт хэргийн тоо бүр ч түргэн өсчээ. Энд эрүүгийн гэмт хэргээр 1819 онд зөвхөн 89 хүнийг баривчилсан бол 1837 онд даруй 3176, 1842 онд бүр 4189 хүнийг баривчилжээ. Мөн тэр шериф Алисоны албан ёсны тайланг үзэхэд Ланкаширт 30 жилд хүн ам нь 2 дахин нэмэгдсэн байхад 1-2 жилд гэмт хэргийн тоо хүн амын өсөлтөөс 6 дахин өсчээ. Уг гэмт хэргүүдийн тухайд гэвэл гэмт хэргүүдийн ихээхэн олонхи нь соёлт бүх орнуудтай нэг адил өмчийн эсрэг гэмт хэрэг өөрөөр хэлбэл ямар нэг хэлбэрээр гачигдлаас шалтгаалан гарсан гэмт хэргүүд байгаа бөгөөд учир нь хэн ч өөртөө байгаа юмыг бусдаас хулгайлахгүй шүү дээ. 141-142-р тал. Тахир дутуучуудын сургуулийн нэг манаач нэг тасгаас хэлгүй дүлий охиныг аваачиж, дөрөв хоног орондоо нууж хамт унтаж байжээ. 304-р тал.

15. Хулгай

(Бүх гэмт хэргүүд дотроос хулгайн гэмт хэрэг хамгийн их байгаа бөгөөд жил ирэх бүр тоо нь улам бүр өсч байна. 1990 онд хулгайн гэмт хэрэг 3212 гарсан бол 1995 онд 12.141 болж 3.8 дахин 1997 онд 13.347 болж 4.2 дахин өсч оргил цэгтээ хүрч байв.)

...Ажилчны бүх байдал, түүний орчин тойрны нөхцөл нь түүнд ёс суртахуунгүй байдал хөгжихөд тус дөхөм болж байна. Ядуу амьдралд ямар ч сайн сайхан юм байхгүй, аливаа жаргал цэнгэл түүнд бараг хүртээлгүй. Пролетари нарт хулгай хийхгүй байх ямар үндэс байж болох вэ? "Хувийн өмч онгон дархан" гэдэг үг хөрөнгөтөнд маш тааламжтай, маш сайхан сонсогддог. Харин ямар ч өмчгүй хүний хувьд хувийн өмчийн онгон дархан гэдэг нь аяндаа арилдаг. Ядуурлын туйлд хүрээд байхдаа ч хулгай хийхгүй тийм ёс суртахуун журамтай хүн ажилчдын дотор олон байдаг. Чухам тийм хүмүүс амиа хорлож үхдэг. 152-р тал

16. Биеэ үнэлэгчид

(Зөвхөн Улаанбаатар хотод 1000 гаруй эмэгтэйчүүд тогтмол биеэ үнэлж байна. Улаанбаатар хотын цагдаагийн газрын мэдээллээс. Бие үнэлэгч охидын дунд явуулсан судалгаанаас үзэхэд 71.8 хувь нь тэнэмэл, 70.2 хувь нь ажилгүй болон сургууль завсардсан охид биеэ үнэлж байна хэмээн

хариулжээ. МУИС. ХАССТ. ...Миний биеэ үнэлэх болсон шалтгаан гэвэл ажил олдохгүй хэдэн хүүхдээ өлсгөж үхүүлэхгүйн тулд ингэж явна даа. Янханы ярилцлага. Шар сонин 2001 №15)

...Английн олон ажилчдын өөр нэгэн дутагдал нь спиртлэг ундааг тэвчихгүй байгаагийн зэрэгцээгээр эр эмийн харилцааны талаар замбараагүй байгаа явдал юм. Ажилчид амьдралдаа жаахан ч гэсэн жаргахын тулд энэ хоёр цэнгэлрүү шургуу дайрч, тэдгээрт хэтэрхий замбараагүй автаж байна. Орой бүр (Улаанбаатарын Ч.Т) гудамжуудыг янхан дүүргэж байна. Тэд өлбөрч үхэхгүйн тулд дайралдсан эр хүн бүрт биеэ үнэлэхээс буцахгүй байна. 139-р тал. Хүүхдүүд бүр багаасаа бэлгийн эмх замбараагүй харилцаанд орох, бүр 14-15 наснаасаа янхан болох явдал (Улаанбаатарт Ч.Т) ихэд дэлгэрсэн байна. 215-р тал.

17. Орон гэргүйчүүд

(Английн хүүхдийг ивээх сангийн мэдээлснээр монголд 2000 гаруй хүн орох оронгүй тэнүүчилж байна. Тэд УБ хотод байдаг 80 орчим траншейд амьдардаг байна.)

...Өглөө бүр сэрээд дараачийн шөнийг хаана өнгөрүүлэхээ мэдэхээ больсон олон хүн байна. Тэдний хамгийн азтайнууд нь хоноглох байр олох бөгөөд тэнд тэд пиг дүүрч өвчтэй, эрүүл, эрэгтэй эмэгтэй, согтуу эрүүл ялгаагүй шахцалдан унтдаг. Янз бүрийн хэрүүл, зодоон цохион ч гарч заримдаа үгээр илэрхийлэхийн аргагүй тийм балмад зэрлэг явдал гардаг. Хэдийгээр "асрах газрууд" үйл ажиллагаа явуулж байгаа ч тэд хүйтний улиралд гадаа хонож байна. 42-р тал. Тэд гэр бүлээрээ гудамжаар хэсүүлэн явж энд тэнд зогсон, гунигтай дуу дуулах буюу гудамжаар явж байгаа хүмүүст өрөвдөхийг хүссэн үг хэлдэг. 96-р тал.

...Хүүхдүүд өдөрт 12-14 цаг (зах дээр Ч.Т) ажиллаж, нооронхой хувцас өмсөж, цадталаа хоол идэхгүй, зодуулж занчуулан хэдэн өдрөөр эмзэглэн явдаг байна. 213-р тал. ...Саяхан болтол дээд ангиудын эдэлдэг атаархмаар эрх дарх болж байсан амиа хорлох явдал Англид пролетари нарын дунд ч жирийн үзэгдэл болоод үй олон ядуу хүн гуйланчлалаас гарах өөр замгүй болохоор түүнээс ангижрахын тулд амиа хоролдог болжээ. 126-р тал.

18. Архидалт

(...Наркологи судлаач Эрдэнэбаярын мэдээлснээр манай улсын насанд хүрсэн хүн амын 52 хувь нь архи хэтрүүлэн хэрэглэдэг байна. Нэг хүнд ноогдох архины хэмжээ дэлхийд дунджаар 8-10 литр байдаг бол манай улсад үүнээс 2 дахин их байна. ...Улсын хэмжээгээр 250 нэр төрлийн архиийг 175 компани үйлдвэрлэж байна. МН-Өнөөдөр 2001.11-16 ...Монгол улсын хэмжээгээр нийтдээ архи худалдаалдаг, 3738 цэг байгаа бөгөөд зөвхөн Улаанбаатар хотод 1624 цэг үйл ажиллагаагаа явуулж байна. Улаанбаатар сонин. 2001-12-14 ... Монголд 700 гаруй ломбард үйл ажиллагаа явуулж байна.)

...Ажилчид архи их уудаг нь үнэхээр аргагүй юм. Энэ хотод (Улаанбаатарт Ч.Т) (1990 онд Ч.Т) маш цөөхөн архины мухлаг байсан бол (2000 онд Ч.Т) байшин болгонд нэг архины мухлаг оногддог болжээ. Бараг (байшин бүрд) пивоны газар дайралдах бөгөөд үүнээс гадна архи пиво зөвшөөрөлгүй худалддаг нууц газрууд цагдаа очдоггүй холын дүүргүүдэд байдаг ба тэнд спиртийг маш их хэмжээгээр нууцгай зардаг байна. Түүнээс гадна (Улаанбаатарт) өчнөөн олон архины үйлдвэр ажиллаж байна. ...Ажилчныг архи руу түлхэж байгаа шалтгаан гэвэл олонхийн жишээ, хангалтгүй хүмүүжил, залуу хүмүүсийг уруу татагдахаас хаацайлах боломжгүй байдал, архичин эцэг эх нь хүүхдүүдээ дарсаар дайлах нь олонтоо байдгийн шууд нөлөө, спиртийн мансууралд амьдралын дарлал, гачигдлыг хэдхэн цаг ч гэсэн мартана гэдэг найдлага зэрэг хэдэн зуун шалтгаан нөлөөлдөг. Энд ууж согтуурах явдал бол түүнд татагдсан хүнийг буруушаах дутагдал байхаа больжээ. 112-р тал. ...Ажилчид цалин хөлсөө авсны дараа, ажил арай эрт зогсоод, бямба гаригийн орой архидан согтуурах явдлын бүх муу муухайг харж болно. Ням гаригийн орой мөн тийм үзэгдэл дахин гардаг. Архичид хамаг мөнгөө үрчихээд, том хот бүрд олон байдаг аль тааралдсан ломбардын газарт очиж, юу байгаагаа барьцаанд өгдөг бөгөөд тийм ломбардын газар байдаг. Хогшил тавилга, байвал гоёлын хуцас мөн сав суулга тэргүүтнийг өдий төдийгөөр нь ломбардад тавьж, дуустал нь үргэлжилдэг байна. Ууж согтуурах явдал Английн ажилчдын дотор дэлгэрснийг өөрийнхөө нүдээр үзэж мэдэрсэн хүн, ажилчид жил бүр спиртлэг ундаанд хамаг мөнгөө зарж байдгийг үнэмшинэ. 138-р тал.

...Ууж согтуурах нь ажилчны амьдралын нөхцөлүүдийн улмаас тэднийг элдэв өвчинд өртөмтгий болгож уушиг, ходоодны өвчин, балнад дэлгэрэхэд дөхөм болж байна. 112-р тал.

19. Цэрэг татлага

(Цэрэг татлагын комиссын үзлэгээр орж байгаа залуучуудын 70-80 хувь нь ямар нэгэн өвчтэй болох нь тогтоогджээ. Зөвхөн Нийслэл хотод гэхэд 2001 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагаар орсон эрчүүдийн 28 хувь нь эрүүл мэндээр тэнцээгүй байна. МН-Өнөөдөр 2001-11-9 1262.)

...Ажилчид намхан нуруутай, чадал тэнхээгээр маш дорой байна. Үүнээс гадна олон ажилчны бие, ууц нуруу гажиж гэмтсэн байдал харагдаж байна... гэж шинэ цэрэг комиссын эмч хэлжээ. Шинэ цэрэг татах ажилд оролцсон бага даргын гэрчилснээр эрэгтэйчүүдийн өндөр тэнцдэггүй бөгөөд цэрэгт татагдсан 613 хүнээс зөвхөн 238 нь тэнцсэн байна.

20. Цагдаа, шүүх

(Судалгаанаас үзвэл авилгал хамгийн их авдаг газруудын нэгэнд шүүх орсон байна. Авилгалын эсрэг судалгааны тайлан. UNDP. Удирдлагын академи. 1999. ...МУИС социологийн тэнхмээс 2001 оны 8 сард явуулсан судалгаанаас харвал нийт оролцогчдын 50 орчим хувь нь прокурор өөрийн үүргийг гүйцэтгэж чадахгүй байна, гэсэн бол 40 хувь нь хариулж мэдэхгүй байна хэмээн хариулахаас татгалзаж дөнгөж 5 хувь нь үүргээ сайн биелүүлдэг хэмээжээ. ...Хуулийнхан төрийн өндөр албан тушаалтнуудад өндөг шиг бөөрөнхий, энгийн иргэдэд ирт мэс шиг ханддаг болсон. ЦЕГ.ажилтан хурандаа Л.Билгээ. МН-Өнөөдөр 2001-11-17)

...Хөрөнгөтөн юу ч хийж байлаа гэсэн цагдаа тэдэнтэй ямагт эелдэг харилцаатай байж харин пролетари нартай бүдүүлэг хэрцгий харилцаж байдаг байна. Ядуу байдал нь өөрөө аяндаа гэмт хэрэгт сэрдэгдэж, баячуудын дураараа дургих эрх мэдлээс хамгаалах хууль ёсны арга хэрэгсэлгүй болгодог. Ийм учраас хуулийн хамгаалах хэлбэр пролетарийн хувьд байдаггүй бөгөөд цагдаа нар гэрт нь эрээ цээргүй дайран орж, тэднийг баривчлан дур мэдэн цээрлүүлж байдаг.295-р тал. Баян хүнийг шүүхэд дуудах буюу урихдаа шүүгч нар тайван байдлыг нь алдагдуулсандаа гүнзгий харамсаж байгаагаа илэрхийлж, уг хэргийг баяны ашиг тусд нийцүүлэн явуулахыг аль болохоор оролддог. Баяныг шийтгэхээс өөр аргагүй болоход шүүгч бас дахин онцгой харамсал илэрхийлэх зэргээр сүйд майд болдог. Тэгээд өчүүхэн хэмжээний мөнгөн торгууль оногдуулахад хөрөнгөтөн түүнийг үл тоомсорлон ширээн дээр нь шидчихээд гардаг байна. Харин ядуу хүн шүүхийн өмнө очих ёстой болвол өөртэй нь ижил бусад хүмүүсийн хамт урьдаар шоронд хонох ёстой болдог. Эхлэхээсээ аваад түүнийг ялтан гэж үзэж, зандран харааж, өөрийгөө зөвтгөх гэж оролдвол "Бид тэгж булзааруулдгийг чинь мэднэ" хэмээн зэвүүрхэн хариулна. Уг хэрэг түүний төлж дийлэхгүй торгууль оногдуулах явдлаар дуусч, нэг юмуу хэдэн сараар шоронд суухаас өөр аргагүй болдог байна. Түүнд ямар нэг гэмт хэрэг тулгаж болохгүй байлаа ч гэсэн түүнийг луйварчин, хэрмэл гэж шоронд хорино. 294-р тал.

...Газар бүхэнд хуулийн хамгаалалтын дор бие биенийгээ дээрэмдэж, энэ бүхнийг тун ичгүүр сонжуургүй, илэн далангүй хийж байгаа учраас энд ийм ил харагдаж байгаа манай нийгмийн байгууллын үр дагаврыг бодоход их аймаар санагдах боловч одоо болтол энэ ухаан жолоогүй орчлын дотор хамаг юм хараахан сүйрээгүй байгааг гайхна уу гэхээс биш өөр юуг ч гайхах зүйлгүй болж байна. 34-р тал.

Дүгнэлтийн оронд

(2001 оны байдлаар Монгол улсын харьяатаас гарах 30.5 мянга орчим хүсэлт ирээд байгаа бөгөөд Ерөнхийлөгчийн зарлигаар 15419 хүний харьяатаас гарах асуудлыг шийдвэрлэсэн байна. МН-Өнөөдөр 2001-12-8 Энэ тоо нь цөөхөн хүн амтай манай оронд хэтэрхий ахадсан тоо юм.)

Ингээд та бүхэнд танилцуулсан товчхон аялалаа өндөрлөе. Энд монголын нийгэмд өдгөө соёл иргэншлийн хөгжлийн сөрөг үр дагавар болсон сэтгэцийн эмгэгтэй 250,000 хүний тухай, арван долоо, сүүлийн үеийн мэдээгээр 30 хутгалж хүн алж байгаа тухай, авто ослоор олон хүн амиа алдаж, гэмтэж, бэртэж байгаа тухай, такси хөлөглөсөн олон арван дээрэмчид хүн дээрэмдэж байгаа тухай, мянга мянган залуу гэр бүл салж байгаа эмгэнэлт мэдээний тухай, гэр бүлийн дотоод харилцаа сүйрч байгаа тухай, оршуулгын газар ухдаг хүнд рокер залуучуудын тухай, уламжлалт болон гадны шашны

урсгалуудын тэмцлийн тухай, монголын гэр бүлийн өрийн сүлжээний тухай, зэрэг олон асуудлууд зүй ёсоор орхигдлоо. Учир нь энэ бүхэн нь орчин үеийн нийгмийн бидний өөрсдийн судлах асуудал мөн.

Манай монголын өнөөгийн нийгэм уламжлагдаж ирсэн асуудлуудыг шийдвэрлэж чадаагүй байхад соёл иргэншлийн шинэ сөрөг асуудлуудтай тулгарч байна.

Гэвч энэ бүх нийгмийн сөрөг үзэгдлийг дурдсанаар би "Орон бүхний пролетари нар нэгдэгтүн" гэж уриалах гэсэнгүй. Энэ өгүүллийг бичсэнээр хуучныг санагалзсан, коммунист үзэл суртлаас салж чадаагүй хэмээн зэмлэх хүн гарахгүй байх гэж найдна. Өөрөөр хэлбэл тэр нийгмийг чинь би мэдэхгүй. Тийм ч учраас хуучин нийгмийг санагалзагчдын тоонд би орохгүй. Нөгөө талаас би нийгмийн өнөөгийн байдал болон хөгжил, цаашдын хандлагын талаар хийсвэрээр онолдоогүй байна. Учир нь Энгельсийн 150 гаруй жилийн өмнө судалсан тэр "зэрлэг капитализмыг" бид өөрсдөө өдөр тутмын амьдралаасаа харж байна. Мөн судалгаа хийж нийгмийн янз бүрийн бүлэг давхаргын хүмүүстэй уулзаж явдгийн хувьд монголын өнөөгийн нийгмийг ажил, гэр, хэвлэл мэдээлэл гурваас авсан мэдээллээр дүгнэдэг хийсвэр онолчдоос илүүтэй мэднэ хэмээн хэлэх үндэстэй. Би марксизм дахин соёлох болов гэж нотлох гээгүй байна.

Ямар ч нийгэмд нийгмийн доод хэсэг ядуучууд гэж байдгийг би үгүйсгэх гээгүй. Тоталитар дэглэмтэй төвлөрсөн эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн систем рүү шилжиж байгаа өнөө үед ихэнхи хүмүүсийн амьдрал хүнд байгааг хүн бүр мэдэж байгаа. Хүний хөгжлийн судалгаагаар ядуу баяны ялгааг харуулдаг "Жин" -ийн коэффициент сүүлийн жилд 4 пунктээр нэмэгдсэн байна. Өнгөрсөн 10 жилийн үйл ажиллагааны үр дүнд нийгэмд мань эерэгээс гадна сөрөг зүйлс улам ихэссээр байна. Бид ололт амжилтаа магтахаас гадна нийгэмд бодитой оршиж байгаа эмгэг гажуудлаа судлан нээлттэй хэлэлцэх ёстой. Энэ талаар социологчидийн өдөөлт, хэлэлцүүлэг, судалгааны дүнгүүд нэгэнтээ гараад эхэлсэн байна. Үүнд С.Дашдаваа, Д.Ганхуяг зэрэг хүмүүсийг дурдаж болох юм.

Хувийн авьяас, чадвар өрсөлдөөнөөр гарч ирэх ёстой гэж ойлгож байсан баячууд мань авилгал, танил тал, хууль бус наймаа, эрх мэдлээ ашиглах, хулгай хийх, луйвардах, одоо бүр рекетлэх замаар хөрөнгөжиж улмаар "шинэ монголчууд" болон төлөвшиж байна.

Ямар нэгэн байдлаар ядууд тооцогдож байгаа нийт хүн амын 40 хувийг (энэ бол ихээхэн багасгасан тоо) бүрдүүлж буй хүмүүст уг нь амьдралаа дээшлүүлэх боломж нь байгаа гэж хэлбэл би үнэмшихгүй. Эдгээр бүх хүмүүсийг арчаагүй, амьдралын төлөө тэмцэхгүй байгаа гэж хэлбэл би итгэхгүй.

Эцсийн эцэст бидний зорилго ардчилал, зах зээлийн нийгэм юм уу эсвэл иргэдийн сайн сайхан амьдрал юм уу? Хэрвээ ардчилал, зах зээлийн нийгэм зорилго нь мөн гэж хариулбал бид зорилгодоо нэгэнт хүрчээ. Уг нь ардчилал зах зээлийн нийгмээр дамжиж иргэдийн сайн сайхан амьдралд хүрэх гэсэн байлтай. Өөрөөр хэлбэл бид шилжилтээр иргэдийнхээ амьдралыг улс орныхоо байдлыг сайжруулах гэсэн байлтай.

Орос хэлийг англи хэлээр сольж, орос соёл, амьдрал хэв маягийг өрнөдийн соёл, амьдрах хэв маягаар сольж, эх орны дайны тухай орос киног иргэний дайн, гэмт хэргийн тухай америк киногоор сольж, орос номоос хуулдагаа болиод орос биш л бол хаанаас ч хамаагүй хуулдаг болж, үгүй ядаж нөгөө авдаг зээл тусламж нь багассангүй ЗХУ болон ЭЗХТ нийгэмлэгээс авдаг байсан зээл тусламжийг Япон болон өрнөдийн бусад орноос авч, орос зөвлөхүүдийг Валютын сан зэрэг бусад байгууллагуудын зөвлөхөөр сольж байгаад чухам ямар ялгаа байгаа юм бэ? Хэт тэгшитгэлээс хэт тэнцвэргүй байдалруу явахыг хүссэн хүн байсан юмуу? Бид үйлдвэрлэх чадваргүй байгаа нь социализмын үеийн харалган бодлогоос гадна жижиг системийн сул тал, том орнуудын бодлого юм биш байгаа?

Зөвхөн өөртөө хэрэгтэй баримтыг түүн авсан байна хэмээсэн шүүмжлэлийг би зүй ёсоор хүлээн авна. Гэхдээ ийнхүү шүүмжлэх хүн тэр миний өөртөө түүн цуглуулсан баримтуудаас харахад 150 жилийн өмнөх английн нийгэм монголын нийгэм хоёр дэндүү олон баримтаар, шинж тэмдгээр ижил төсөөтэй байгааг юу гэж хэлэх вэ? гэсэн асуултанд хариулах хэрэгтэй болох юм. Энд үндсэн нэр томъёоноос эхлээд түүхэн тодорхой үеүүдэд шинжлэх ухааны аналогийг хийх, харьцуулах,

түүхчлэх, гэх мэт онолын боловсруулалт хийн нухацтай судлах шаардлагатай байгаа гэдэг нь мэдээж. Энэхүү хэрэгцээ шаардлагыг үндэслэн эцэст хэлэхэд тус өгүүллийг дэлгэрүүлэн "Монгол дахь ажилчин ангийн байдал: 150 жилийн дараа" гэсэн түүхийн социологийн харьцуулсан судалгааг явуулан олны хүртээл болгох санаа өвөрлөж буйгаа дурдахын ялдамд хэрвээ тэгэх зав, боломж олдвол "Монгол дахь зэрлэг капитализмын" асуудлын онолын үндэслэл, судалгаа, баримт, нотолгоо зэргийг танд хангалттай танилцуулахыг хичээх болно. Мөн үүнд таны шүүмжлэл, эрдэмтэн багш нар зөвлөгөө хэрэгтэй болох буй заа. Ингээд Америкийн томоохон капиталист Ж.Соросын "Нээлттэй нийгмийн гол дайсан нь коммунист дэглэмийн урт удаан хугацааны ноёрхол бус харин капитализмын сөрөг үзэгдлүүд юм." гэсэн (Өнөөдөр 1997-6-13 Ж.Сорос.Капитализмын аюул занал) алдарт үгээр цэг хатгасу.